

НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН МЭДЭЭЛЛИЙН СИСТЕМИЙН ЗАГВАР

Т. Жааваа

Хөгжлийн зурваст үндэсний эдийн засгийн бүтэц, маркетинг, менежмент хэв шинж, философид нийцсэн нягтлан бодох бүртгэлийн мэдээллийн системийг загварчлах нь зайлшгүй болсон. Мэргэжлийн олон сэдэв: мэдээллийн эдийн засаг /үнэ цэнэ/, хэмжлийн загвар, макро төвшний нэгтгэл /үндэсний тооцооны систем/, хэрэглээний аспектүүд төгс судлагдаагүй. Эртний монголын мөнгө зоос, өртөө, татварын бүртгэл, дэлхий, бүс нутгийн глобал систем, XXI зууны мэдээллийн технологи, даяаршлын эрч хүч ба менежмент шинэтгэл зэрэг олон сэдвүүд судлаачийг хүлээсээр буй. /См: Т.Жааваа "Вопросы обновления системы бухгалтерского учета", Автореферат диссертации на соискание ученой степени доктора экономических наук, Улан-Батор, 2003г, с.3/

Зорилгодоо хүрэхийн тулд мэдээллийн технологи ба менежмент хувьслын чиг, судлах зүйлийн концепц, бүс нутгуудын системийн төлөвшилд орчны тандалт хийв. Үндэсний бүртгэлийн тогтолцоо ба мэдээллийн системийг загварчлахад орчны ийм тандалт их чухал гэж үзсэн. Учир нь даяаршил, хувьслын хүч бүс нутаг, улс гүрний хэв шинж, уламжлал, ёс зүй, соёл, зан үйлд их өөрчлөлтийг бий болгож, мэдээллийн технологи, мэргэжлийн хяналт ба судалгаа хөгжилд илт нөлөөлж эхэлсэн.

Эртний түүхээс улбаатай нягтлан бодох бүртгэлийн мэдээллийн системийн дэвшил хөгжил улс гүрний үндэсний банк, санхүү, мөнгөний бодлого төдийгүй макро микро төвшний жолоодлого, менежмент хэв шинж, бизнес хувьсал, эдийн засгийн чөлөөт /төгс/, олигополь өрсөлдөөн ба монополь ноёрхолт бүтэц, үнэт цаас, санхүүгийн зах зээлийн төлөвшилд их үүрэг гүйцэтгэсэн. Дундад зууны сэргэн мандлаас эдүгээ хүртэл их бизнест хөл тавьсан Итали, Англи, Америк, Япон, Зүүн Өмнөт Ази, Хятадын түүхэн сургамж, менежмент хувьслууд санхүү, татвар, зардал, удирдлагын

бүртгэлийн мэдээллийн ач холбогдлыг тод илтгэдэг. /"Даяар бүртгэлийн давхар бичилтийн түүх", нэг сэдэвт хамтын бүтээл, Нью Майнд технологи ХХК, УБ, 2003, 11-13 тал/

Бид Дэлхийн /XV-XXI зуун/ бизнес ертөнц, менежмент хувьслын түүх, XXI зууны мэдээллийн технологи ба системийн чиг хандлагыг сэтгэлгээний сүүлийн /интернет веб сайтууд/ сурвалжаар тандаж, дараах дүгнэлт ба таамаг дэвшүүлж, ойрын 20 жилээр баталгаа өгч буй.

Нэгд, Мэдээллийн технологи, даяаршлын эрч хүч ба орчны өөрчлөлтүүд - мэргэжлийн хувьслын гол хөтлөгч. Үндсэн шинжүүд: нэгдсэн мөнгөн тэмдэгт, хэл, ёс зүй, е-худалдаа, санхүүгийн зуучийн үйлчилгээ гэж үзлээ. /См: Дэлхийн Нягтлан Бодогчдын Холбоо /IFAC/, Нягтлан бодох бүртгэлийн судалгаа, шинжилгээний олон улсын /IAIR/ төвийн веб сайт, Австралийн Мэргэшсэн Нягтлан Бодогчдын Институтын /1998 он/ орчны тандалт, "Мэргэжлийн хөтөлбөр - 2020" хувилбар/. Өнөөдөр он-лайн систем, е-худалдаа жирийн хэрэглээ болж, алиев хэлцэл, төлбөр, солилцоо цахим карт, интернетээр хийгдэн, огт мэдэхгүй талууд үйлдэхүүнээ веб сайтаар санал болгож эхлэв. Мэдээллийн /кибер/ задгай орчны эрсдэл, хяналт, хамгаалалт, бэлтгэгчийн ёс зүй, ялангуяа Hackeryудтай тэмцэж, Anti Virus, Cookies хамгаалалт, World Wide Web, Web Trust сүлжээний нууцлал, хамгаалалт, хяналтын горимыг бүтээх ч шаардлага буй. /Английн мэргэшсэн нягтлан бодогчдын институт, Чарльз Стюртын их сургуулийн "Ёс зүй, электрон худалдаа" хэлэлцүүлэг, 1999 он/

Хоёрт, Алиев сэтгэлгээний томъёололд системийн онол, шинжилгээний хандлагын арга хэрэглэвэл семантик /агуулга, хэлбэр/, прагматик /өгөөж, хэрэглээ/, синтаксик /бүтэц, байгууламж/ гэсэн 3 хэмжээст хамаарлын холбоос, загвар ба координат заавал үүснэ. Мэргэжлийн сэтгэлгээнд персоналист, бихевиорист, материалист чиглэл урсгал их түгсэн ч үүнтэй холбоотой. Персонализм ба бихевиоризм хүмүүсийн зан үйл, эрх мэдэл, хариуцлага, үйл хөдлөл, үзэл бодол, сонирхол, материализм өмч, баялаг, үнэт зүйлс, эх үүсвэр, хэрэглүүрт онц ач холбогдол өгчээ. XXI зууны мэдээллийн технологи, орчны өөрчлөлт, мэргэжлийн хувьслын чигээс судлагдахууны синтаксик чиглэл, персонализмыг түлхүү хөгжүүлэх нь зайлшгүй болсон.

Гуравт, Бүс нутгийн мэдээллийн загварыг судлах нь хувьслын төлөв, үндэсний тооцооны тогтолцоо, татвар, санхүү, хуулийн зохицол, хамаарлыг тогтооход чухал нөлөөтэй. Их эртний Европ систем /XV-XXI зуун/ чөлөөт үйлдвэрлэгч бүхий хувийн хэвшлийн тусгал болж үүссэн бол чөлөөт, олигополь, монополь өрсөлдөөн ба ноёрхолт эдийн засгийн бүтэц, үнэт цаас, капиталын зах зээлийн тусгал болж Англи-сагсон /XIX-XX зуун/ загвар томъёологдсон. Харин даяаршлын эрч хүч ба мэдээллийн технологи, орчны хувьслууд "НББОУС" глобал систем /1975-2003/ үүсэхэд хүргэжээ. Бид Зүүн Европ, Төв, Зүүн Өмнөт Ази, Африк, Латин Америкийн шилжилтийн эдийн засагтай гүрнийг 6 бүлэгт хуваав.

Тавд, Даяаршлын глобал систем төв тэнхлэгт үндэсний түүх /цаг хугацааны хамаарал/, соёлын /орон зайн онцлог/ өв, шилжилтийн хэв шинж, зах зээлийн бүтэц, уламжлал, онцлогт нийцсэн мэдээллийн систем загварын

хэв шинж, бүрдэл, бодлого зохицол ба хяналтын тогтолцоог зөв томъёолох нь нэн чухал болоод байна. Эхлээд мэргэжлийн хяналтын хэв шинж, хууль, эдийн засаг, соёлын нөлөөг тандаж, шилжилтийн энэ зурваст төрийн статустай мэргэжлийн хяналтын тогтолцоог бүрдүүлэх нь чухал гэсэн дүгнэлт хийсэн. Дараа нь системийн хэв шинжийг Хофстед Геерт (1980), С.Ж Грейн (1988) загвараар оношлож, бүртгэл хөтлөлтийн соёлын үнэлэмж илт доогуур төвшинд буйг (мэргэшүүлэх систем, ур чадварын өсөлт сул, нэг хэв загварын бодлого зохицол, хяналт муу, шинэтгэлд бэлэн бус, хэвшсэн практикийг илүүтэй үздэг, мэдээллийн ассиметр, далд эдийн засаг, авилгал, хууль бус үйлдэл газар авсан) тогтоов. Системийн үнэлэмжийг өсгөх чиглэлд төр засгаас явуулах бодлогын үндсэн чиглэл: нэгд, Улс төр, эдийн засаг, хуулийн орчинг эрүүлжүүлэх, хоёрт, "Судалгаа-зэхэлт-хэрэгжил-хяналт" мөчлөгт бодлого, зохицол, хяналтын нөлөөг дээшлүүлэх, гуравт, Системийн тунхаг, стандарт, тайлбарыг нэг мөр бэлтгэж, бизнес, төсвийн хүрээнд хэвшүүлэх, дөрөвт, Мэргэшүүлэх систем, сургалтын нөлөөг дээшлүүлэхэд оршино.

Зургаа, Үндэсний эдийн засгийг тэтгэх "М" менежмент философийн тухайд систем нь орц гарц, тохируулагчийн чиг үүрэг бүхий шууд ба эргэх холбоог үүсгэгч мэдээллийн сүлжээг хамарна. Системийн санхүү, татварын бүртгэл, аудит үйлчилгээ ба шинжилгээний өгөгдлүүд нь шилжилтийн зурвас дэхь улс гүрний үндэсний тооцооны систем /макро төвшний нэгтгэл/ ба хэрэглэгчдийн бүх давхаргад чиглэсэн гадагш чигт мэдээллийн багцыг үүсгэх бөгөөд түүхэн (НС) ба гүйцэтгэл шингээгч өртөг (АС), нэрлэсэн санхүүгийн капитал ба нягтлан бодохын ашгийн хэмжилд /статис загвар/ суурилах учиртай.

Харин төсөвлөлт, төвлөрсөн бус хяналт, хариуцлага тайлагнал, ситуац шинжилгээ, шийд гаргалт, стратеги төлөвлөлт, зах зээл, үнийн сегментчлэлийн дотогш чигт мэдээллүүд одоогийн өртөг (СС), зах зээлийн үнэ бүрдэл, шууд өртөг (DC), биет капитал, ахиуц (СМ) ба эдийн засгийн ашгийн хэмжилд /динамик загвар/ суурилах нь зүйтэй гэсэн дүгнэлт хийв.

Долоо. Эдүгээ Менежмент Х, У онол, төгс мэдээлэл бүхий Европ, Америкийн \А\, Японы \Я\, хариу үйлдлын \З\ зэрэг глобал системийн менежмент философи их түгжээ. Х онол хуучирсан ч үйлдэхүүний менежмент судас - суурь төсөв, гүйцэтгэл шингээгч зардал, шууд, түүхэн, одоогийн өртөг, нягтлан бодохын, ахиуц, эдийн засгийн ашгийн хэмжлүүд одоо хир ач холбогдлоо алдаагүй. А /Америк/ загвар стратеги төлөвлөлт, борлуулалтын өгөөж, уян хатан төсөв, стандарт өртөг, төвлөрсөн бус хяналт, хариуцлагын тайлан, ваучер хяналтыг хөгжүүлсэн нь борлуулалтын менежментийн үндэс болж, глобал төвшинд түгжээ.

Харин туршилт, дизайн, хувиргалтын мөчлөгт чанар, бүтээмж, өртөг хэмжих "Kaizen", "Target" систем, капитал хөрөнгийн үнэ бүрдэл (САРМ), "Яг цагт нь" (JIT), цэвэр өнөөгийн үнэ цэнэ \NPV\ хэмжил зүй, конвейр, үйлдвэрлэлийн уян хатан технологид нийцсэн үйлдэл суурьт, зорилтот (ABC), багц хяналт бүхий Японы \Я\, хариу үйлдлын \З\ философи ба динамик хэмжлийн загварууд орчин цагийн маркетингийн менежментийн эхийг тавьсан. /Т.Жааваа "Мэргэжлийн хувьслын чиг, систем загварын үзэл баримтлалаас", "Ахмад ба залуу үеийн

зарим нягтлан бодогчдын дурсамж бодрол" товхимол, Монголын нягтлан бодох бүртгэл хөгжүүлэх сан, УБ, 2003, 107-112 тал/

Найм. Монголчуудын түүх, соёлын өв, гар, конвейр системд нийцсэн Z глобал маркетингийн менежмент суурьт "М" загварыг тэтгэх мэдээллийн сүлжээг бүрдлийн хувьд түүхэн (НС), одоогийн өртөг (СС), зах зээлийн үнэ, өнөөгийн үнэ цэнэ (PV), цэвэр өнөөгийн үнэ цэнэ (NPV), капитал хөрөнгийн үнэ бүрдэл (САРМ), нягтлан бодох, ахиуц, эдийн засгийн ашгийн хэмжлийн загвар бүхий гүйцэтгэл ба стандарт шингээгч зардал (АС), шууд өртөг (DC), ажлын захиалга (JC), үе шат (PC), үйлдэл суурьт (ABC), багц хяналт бүхий өртгийн систем, суурь ба уян хатан төсөв, төвлөрсөн бус хяналт, дотоод үнэ, хариуцлагын тайлагнал, хэлбэлзлийн шинжилгээ, захиалгын оновчтой тоо (EOQ), яг цагт нь (JIT) төсөвлөлт хяналт, нөөцийн менежмент горимтой, стратеги төлөвлөлт, зах зээл, үнэ бүрдэл, сегментчлэл суурьт маркетингийн удирдлагатай байна гэсэн таамаг дэвшүүлж, систем загварт томъёолсон.

Ашигласан эх сурвалж

Colin Drury. Costing an introduction in 3-rd edition: Орос орчуулга, -М.: "Аудит", "ЮНИТИ", 1998, 774 с

Donald E. Kieso, Jerry J. Weygandt Intermediate accounting, seventh edition: Монгол орчуулга, УБ, 2000 он, 42 тал

Eldon S. Hendricksen, Accounting Theory, 3rd edition, (Homewood, Ill.; Richard D. Irwin, Inc., 1982), p.421

Т.Жааваа "Санхүү, өртөг, удирдлагын бүртгэлийн төлөвшил, шинэтгэл дэхь нэн тулгамдсан асуудлууд", нэг сэдэвт бүтээл, УБ, 2002 он, 200х

Даяар бүртгэлийн давхар бичилтийн түүх, нэг сэдэвт хамтын бүтээл, Нью Майнд технологи ХХК, УБ, 2003, 210х

Т.Жааваа "Үндэсний бүртгэлийн системийг шинэчлэх үзэл баримтлал", шинжлэх ухааны докторын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл, УБ, 2003, 175х

Т.Жааваа "Вопросы обновления системы бухгалтерского учета", Автореферат диссертации на соискание ученой степени доктора экономических наук, Улан-Батор, 2003г, 36 с

Т.Жааваа "XXI зууны мэдээллийн технологи, даяаршил, шинэтгэлийн төлөв", "Санхүүгийн мэдээ" сонин, 2003.06.10, № 16 \124\

Т.Жааваа "Мэргэжлийн хувьслын чиг, систем загварын үзэл баримтлалаас", "Ахмад ба залуу үеийн зарим нягтлан бодогчдын дурсамж бодрол" товхимол, Монголын нягтлан бодох бүртгэл хөгжүүлэх сан, УБ, 2003, 107-1112 тал